



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

Г Гадаадад сургалтын төрийн сангийн
зээлээр суралцуулах тухай Г

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг үндэслэн Монгол Улсын их сургуулийн багш нарын чадавхийг дээшлүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Пүрэвсамбуугийн Туулыг Бүгд Найрамдах Австри Улсын Венийн анагаах ухааны их сургуулийн докторантурт Хавдар судлалын чиглэлээр 3 жилийн, Энхбаярын Азжаргалыг Япон Улсын Токушимагийн их сургуулийн докторантурт Иргэний болон байгаль орчны инженерийн чиглэлээр 3 жилийн хугацаатайгаар суралцуулсугай.
2. Суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР